



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чандмань-Баянхонгор ХК-ны 2021оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2022/2/НА-СТА-ОНӨААН

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Баянхонгор 2022 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат</p> <p>Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: А.Цээням</p> <p>Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn</p> <p>Аудитор: Н.Бүнчинсүрэн</p> <p>Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsuren@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	7
3.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	7
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	7
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	7
4. Аудитын тайлан.....	11
4.1 Ерөнхий зүйл.....	11
4.2 Дотоод хяналт.....	11
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
4.4 Материаллаг байдал	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
5.1 Шилэн дансны мэдээлэл	12
6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
8. Аудитын илрүүлэлт	13
8.1 Төлбөрийн акт.....	13
8.2 Зөвлөмж	14
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт

ЧАНДМАНЬ БАЯНХОНГОР ХК-НЫ
ЗАХИРАЛ М.МӨНХБАТ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Чандмань Баянхонгор ХК-ны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Чандмань Баянхонгор ХК-ний 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

			/төгрөгөөр/
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 1-р сарын 01	2020 оны 12 дугаар сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	11,550,090.82	79,566,540.37
1.1.2	Дансны авлага	138,265,099.77	256,433,285.93
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	7,602,980.94	0.00
1.1.4	Бусад авлага	34,053,339.94	0.00
1.1.6	Бараа материал	130,664,548.37	142,686,441.79
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0.01	0
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	322,136,059.85	478,686,268.09
1.2.1	Үндсэн хөрөнгө	6,238,462,746.92	6,276,238,968.08
1.2.2	Биет бус хөрөнгө	449,509,836.55	450,554,482.93
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,687,972,583.47	6,726,793,451.01
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,010,108,643.32	7,205,479,719.10
2.1.1.1	Дансны өглөг	62,305,551.96	7,837,000.00
2.1.1.3	Татварын өр	120,958,921.61	21,199,967.22
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.01	0
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	183,264,473.58	29,036,967.22
2.1.2.1	Урт хугацаат зээл	135,676,610.77	84,361,356.67
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	135,676,610.77	84,361,356.67
2.2	Өр төлбөрийн нийт дүн	318,941,084.35	113,398,323.89
2.3.1	Өмч:-төрийн	313,835,027.38	313,835,027.38
2.3.2	хувийн	78,458,800.00	78,458,800.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	595,487,073.82	595,487,073.82
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	5,328,308,403.68	5,684,050,465.28
2.3.9	Хуримтлагдсан ашиг	375,078,254.09	420,250,028.73
2.3.11	Эздийн өмчийн дүн	6,691,167,558.97	7,092,081,395.21
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	7,010,108,643.32	7,205,479,719.10

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

			/төгрөгөөр/
Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,754,415,079.28	2,107,322,892.10
2	Борлуулалтын өртөг	1,787,387,333.99	1,995,316,923.95
3	Нийт ашиг(алдагдал)	-32,972,254.71	112,005,968.15
5	Хүүний орлого	1,080,415.20	46,441.49
8	Бусад орлого	92,838,927.07	87,719,373.32
10	Ерөнхий ба удирдлагын зардал	68,918,286.30	50,275,792.49
12	Бусад зардал	27,175,042.11	65,492,931.08
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-45,264,696.82	-18,800,836.06
17	Бусад ашиг (алдагдал)	-52,805,574.78	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-133,216,512.45	65,202,223.33
19	Орлогын татварын зардал		3,260,111.17
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-133,216,512.45	61,942,112.16
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-133,216,512.45	61,942,112.16

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

дд	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	392,293,827.38	595,487,073.82	1,411,286,311.10	482,573,490.21	2,881,640,702.51
2	Залруулсан үлдэгдэл	392,293,827.38	595,487,073.82	1,411,286,311.10	482,573,490.21	2,881,640,702.51
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				107,495,236.12	-107,495,236.12
4	Бусад дэлгэрэнгүй орлого			3,917,022,092.58		3,917,022,092.58
5	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	392,293,827.38	595,487,073.82	5,328,308,403.68	375,078,254.09	6,691,167,558.97
6	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-16,770,337.62	-16,770,337.62
7	Залруулсан үлдэгдэл	392,293,827.38	595,487,073.82	5,328,308,403.68	375,078,254.09	6,691,167,558.97
8	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				61,942,112.25	61,942,112.25
9	Бусад дэлгэрэнгүй орлого			355,742,061.60		355,742,061.60
10	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	392,293,827.38	595,487,073.82	5,684,050,465.28	420,250,028.72	7,092,081,395.20

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,800,310,093.60	2,390,902,462.44
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,776,361,279.24	2,306,600,242.44
1.1.4	Буцаан авсан албан татвар	-286,918.18	
1.1.6	Бусад мөнгөн орлого	24,235,732.54	84,302,220.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,903,635,780.23	2,165,001,379.83
1.2.1	Ажиллагчдад төлсөн	593,121,999.56	620,049,889.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	207,047,720.95	225,720,454.06
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	334,319,059.01	464,151,748.68
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	202,551,054.30	216,384,946.68
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	97,716,775.00	119,492,700.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	18,224,396.62	1,910,322.91
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	207,773,466.87	380,174,194.78
1.2.8	Даатгалын зардалд төлсөн	0.00	2,897,737.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	242,881,307.92	134,219,386.72
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-103,325,686.63	225,901,082.61
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,080,415.20	46,441.49
2.1.5	Хүлээн авсан хүүний орлого	1,080,415.20	46,441.49
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		106,615,820.45
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		101,615,820.45
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		5,000,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,080,415.20	(106,569,378.96)
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	26,633,898.36	51,315,254.10
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	26,233,898.36	51,315,254.10
3.2.5	Бусад зарлага	400,000.00	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-26,633,898.36	(51,315,254.10)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-128,879,169.79	68,016,449.55
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	140,429,260.56	11,550,090.82
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,550,090.82	79,566,540.37

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Цэвэр ус хангамж	төг/л	595,073,500.0	657,484,400.00	658,805,100.00	(1,320,700.00)	100.2
Ариутгах татуурга	төг/л	361,854,600.0	412,902,600.00	410,974,170.00	1,928,430.00	99.5
Дулаан хангамж	м3	581,639,800.0	607,835,000.00	675,564,620.00	(67,729,620.00)	111.1
суурь хураамж	тогтмол	102,125,400.0	112,045,600.00	110,467,160.00	1,578,440.00	98.6
Ус түгээх байр	төг/л	101,133,500.0	196,099,200.00	239,987,900.00	(43,888,700.00)	122.4
дүн		1,741,826,800.00	1,986,366,800.00	2,095,798,950.00	(109,432,150.00)	105.5
Шуурхай засвар үйлчилгээ		13,917,100.00	9,854,900.00	11,524,000.00	(1,669,100.00)	116.9
Бусад орлого		92,590,500.00	41,440,000.00	87,765,700.00	(46,325,700.00)	211.8
Дүн		106,507,600.0	51,294,900.00	99,289,700.00	(47,994,800.00)	193.6
Нийт борлуулалт		1,848,334,400.00	2,037,661,700.00	2,195,088,650.00	(157,426,950.00)	107.7
Цалин түүнтэй адилтгах зардал		914,467,100.00	962,332,500.00	948,511,500.00	13,821,000.00	98.6
Цалин түүнтэй адилтгах зардал		785,608,300.00	816,404,400.00	810,995,900.00	5,408,500.00	99.3
НДШ -АО		115,865,000.00	126,524,100.00	120,728,500.00	5,795,600.00	95.4
ТУЗ цалин		11,450,000.00	16,800,000.00	14,700,000.00	2,100,000.00	87.5
ТУЗ НДШ		1,543,800.00	2,604,000.00	2,087,100.00	516,900.00	80.1
Нийгмийн хамгаалал ажиллагсадтай холбоотой зардал		84,484,890.00	79,437,600.00	44,521,600.00	34,916,000.00	56.0
Нэг удаагийн буцалтгүй тусламж		4,200,000.00	1,500,000.00	641,600.00	858,400.00	42.8
Тэтгэмж		23,548,600.00	3,300,000.00	2,500,000.00	800,000.00	75.8
Шагнал урамшууллын зардал		3,658,600.00	4,590,000.00	4,334,000.00	256,000.00	94.4
Баяр ёслол Ажилчдын нийгмийн арга хэмжээнд		27,900,190.00	39,180,000.00	6,685,700.00	32,494,300.00	17.1
Сургалт		2,083,800.00	2,645,000.00	1,355,000.00	1,290,000.00	51.2
Албан томилолтын зардал		3,189,900.00	4,239,500.00	2,880,100.00	1,359,400.00	67.9
Ахмадын зардал		3,510,000.00	6,375,000.00	4,988,500.00	1,386,500.00	78.3
Ажилчдын хоолны зардал		16,393,800.00	17,608,100.00	21,136,700.00	(3,528,600.00)	120.0
Татвар, төлбөр, хураамж, даатгал		74,898,300.00	76,059,600.00	71,053,230.00	5,006,370.00	93.4
авто болон өөрөө явагч хэрэгс.тат		1,786,200.00	1,786,200.00	2,409,200.00	(623,000.00)	134.9
Байгалийн нөөц ашигласны төлбөр		7,590,600.00	8,500,000.00	11,032,700.00	(2,532,700.00)	129.8
Шугам сүлжээний кадастрийн зурагны гүйцэтгэл		-	5,000,000.00	-	5,000,000.00	-
Байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ		-	6,000,000.00	-	6,000,000.00	-
Газрын төлбөр		3,977,500.00	3,977,600.00	1,692,130.00	2,285,470.00	42.5
Үл хөдлөх хөрөнгийн татвар		16,796,000.00	20,317,400.00	27,675,700.00	(7,358,300.00)	136.2
Даатгал		3,478,400.00	3,478,400.00	2,657,700.00	820,700.00	76.4
Аудит		1,300,000.00	1,300,000.00	2,500,000.00	(1,200,000.00)	192.3
Зохицуулах зөвлөл, тусгай зөвшөөрөл		6,881,300.00	11,317,600.00	10,904,800.00	412,800.00	96.4
Зар сурталчилгаа /хэвлэл мэдээлэл/		6,790,900.00	2,400,000.00	2,631,800.00	(231,800.00)	109.7
Зээлийн хүүгийн зардал		11,353,100.00	7,519,600.00	1,910,300.00	5,609,300.00	25.4
Төрөл бүрийн шимтгэл хураамж		3,461,600.00	3,000,000.00	3,433,900.00	(433,900.00)	114.5
Түрээсийн зардал		3,073,600.00	-	1,743,000.00	(1,743,000.00)	
Гайхам GPS		748,800.00	1,372,800.00	1,444,000.00	(71,200.00)	105.2
программын зардал		789,000.00	90,000.00	1,018,000.00	(928,000.00)	1,131.1
Алданги торгууль		6,871,300.00				
Ашиглалтын зардал		540,274,100.00	590,269,300.00	602,597,700.00	(12,328,400.00)	102.1
Эрчим хүч		158,072,000.00	162,001,600.00	162,606,700.00	(605,100.00)	100.4
Үндсэн хөрөнгийн элэгдэл		319,591,700.00	412,030,500.00	421,359,100.00	(9,328,600.00)	102.3
Харилцаа холбооны зардал		17,345,700.00	16,237,200.00	18,631,900.00	(2,394,700.00)	114.7
Үндсэн хөрөнгө актласны гарз		45,264,700.00				
сэлбэг хэрэгсэл /материал/		253,377,070.11	306,346,000.00	285,701,600.00	20,644,400.00	93.3
Түлш, халаалтын зардал		132,953,470.11	151,792,700.00	151,792,700.00	-	100.0
Шатах тослох материал		42,200,800.00	45,740,300.00	53,056,400.00	(7,316,100.00)	116.0
сэлбэг хэрэгсэл /материал/		39,319,300.00	43,372,700.00	36,380,100.00	6,992,600.00	83.9
Бичиг хэргийн зардал		11,410,800.00	5,158,500.00	3,893,800.00	1,264,700.00	75.5
-Ариутгал, цэвэрлэгээ /шинжилгээ		8,167,900.00	15,633,200.00	5,191,600.00	10,441,600.00	33.2
Хөдөлмөр хамгаалал		15,110,600.00	41,266,000.00	31,559,100.00	9,706,900.00	76.5
Цэвэрлэгээний зардал		4,214,200.00	3,382,600.00	3,827,900.00	(445,300.00)	113.2
Засвар үйлчилгээний зардал		48,983,600.00	48,290,500.00	40,992,400.00	7,298,100.00	84.9
Засвар үйлчилгээний зардал		48,331,800.00	47,790,500.00	40,392,400.00	7,398,100.00	84.5
Гэрээт ажлын зардал		651,800.00	500,000.00	600,000.00	(100,000.00)	120.0
Үйл ажиллагааны бус зардал		65,065,800.00	73,805,000.00	136,508,400.00	(62,703,400.00)	185.0
Үйл ажиллагааны бус зардал		52,805,500.00	45,000,000.00	33,758,200.00	11,241,800.00	75.0
Гамшигийн зардал		12,260,300.00	28,805,000.00	5,268,900.00	23,536,100.00	18.3
Хөрөнгө актласны зардал			-	22,834,000.00	(22,834,000.00)	
Найдваргүй авлагын зардал			-	33,868,800.00	(33,868,800.00)	
усны төлбөрийн зөрүү			-	40,778,500.00	(40,778,500.00)	
Нийт зардал		1,981,550,860.11	2,136,540,500.00	2,129,886,430.00	6,654,070.00	99.7
Ашиг алдагдал		(133,216,460.11)	(98,878,800.00)	65,202,220.00	(164,081,020.00)	(65.9)
Орлогын татварын зардал				3,260,111.17	(3,260,111.17)	
Цэвэр ашиг				61,942,112.25	(61,942,112.25)	

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Тайлант хугацаанд “Чандмань Баянхонгор” ХК-Ны зорилго нь “Байгалийн баялгийг үр ашигтай ашиглаж, тэнцвэртэй байдлыг хангаж, эрчимтэй хөгжлийг бүтээнэ”-д оршино.цаанд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

- Гүний усыг зохистой олборлон эрүүл мэнд стандартад тохирсон цэвэр ус түгээх.
- Бохир усыг татан зайлуулан цэвэрлэж, цэвэршилтийн түвшин дээшлүүлж экологийн тэнцвэрийг хадгалах.
- Дулаан хэрэглэгчдийн тохь тухтай байдлыг ханган, горимын дагуу аюулгүй дулаан үйлдвэрлэж хэрэглэгчдийг хангах.
- Удирдлагын бүх түвшинд байгууллагын санхүүгийн чадавхыг нэмэгдүүлж, батлагдсан төсөвт багтааж ажиллах, үр ашиггүй зардлыг тодорхойлон хэмнэж ажиллах.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Чандмань Баянхонгор ХК нь анх 1965 онд үйлчлэх товчоо нэртэйгээр аймгийн төвийн хүн ам, орон сууцны халаалт, цахилгаан эрчим хүч, усан хангамж, хог тээвэр, халуун ус, зочид буудал, хот тохижилт зэрэг үйлчилгээгээр хангах зориулалттай үйл ажиллагаагаа эхэлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2012 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн ээлжит бус XVIII хуралдаанаар “Чандмань-Баянхонгор” ХХК-ийг хаалттай хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн зохион байгуулахаар шийдвэрлэж, хувьцааны 51 хувийг орон нутгийн өмчид, 20 хувийг ажилчдад эзэмшүүлж, 29 хувийг орон нутгийн иргэдэд арилжих шийдвэр гарч хувьцаат компанийн дүрмийг шинэчлэн баталж, 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлсэн байна. Хаалттай хувьцаат компанийг хуулийн дагуу зохион байгуулаагүйгээс тус компанийн үйл ажиллагаа нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн зарчмаар ажиллаж ирсэн байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-гэж заасан байна.

Тус байгууллага нь тайлант онд 2,037,661.7 мянган төгрөгийн орлого, 2,136,540.5 мянган төгрөгийн зарлага 98,878.8 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар ТУЗ-ын 2021.02.05-ны өдрийн 02 дугаар тогтоолоор төсөв батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 2,195,088.6 мянган төгрөгийн орлого, 2,129,886.4 мянган төгрөгийн зарлага гаргаж 65,202.2 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Чандмань-Баянхонгор” санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	11,550.1	79,566.5	68,016.4
Авлага	179,921.4	256,433.3	76,511.9
Урьдчилгаа	0.0	0.0	-
Бараа материал	130,664.5	142,686.4	12,021.9
Үндсэн хөрөнгө	6,687,972.6	6,726,793.5	38,820.9
Нийт хөрөнгийн дүн	7,010,108.6	7,205,479.7	195,371.1
Өр төлбөр	318,941.1	113,398.3	- 205,542.8
Эздийн өмч	6,691,167.6	7,092,081.4	400,913.8
Нийт өр төлбөр ба цэвэр	7,010,108.6	7,205,479.7	195,371.1

Эх сурвалж: 2021 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 79,566.5 мянган төгрөг болж 68,016.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны борлуулалтын орлого 157,426.9 мянган төгрөгөөр давж биелсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 256,433.3 мянган төгрөг болж 76,511.9 мянган төгрөгөөр өссөн нь айл өрх болон байгууллагуудаас авах цэвэр, бохир усны авлага 107,859.2 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Мөн авлага дансны үлдэгдэлд тайлант оны 12 сарын Засгийн газраас олгосон цэвэр бохир усны хөнгөлөлтийн айл өрхийн 98,034.7 мянга, аж ахуй нэгж байгууллагын 113,758.7 мянга, аймгийн Засаг даргын 2021.05.14-ний өдрийн А/311 дугаар захирамжаар аймгийн төвд дулаан үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн уурын зуухны шүүлтүүрийг туршилтаар хийхээр шийдвэр гаргасны дагуу 2021.05.14-нд иргэн Д.Мөнхжаргалд 7,000.0 мянган төгрөг шилжүүлсэн ба уг ажил хийгдээгүй тул авлагаар бүртгэсэн байна.

Тайлант хугацаанд Олон жилийн турш баланст бүртгэлтэй байсан хариуцагч тодорхойгүй гэх шалтгаанаар шүүхийн байгууллагад хандаад ч барагдахгүй байсан 33,868.8 мянган төгрөгийн авлагыг ТУЗ-д танилцуулж, ИТХ-д уламжилснаар ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021.02.01-ний өдрийн 23 дугаар тогтоолоор данснаас хасаж зардлаар бүртгэсэн байна

Бараа материалын дансны үлдэгдэл 142,686.4 мянган төгрөг болж 12,021.9 мянган төгрөгөөр өссөн нь барилгын засварын материал 6,151.9 мянга, сантехникийн сэлбэг 11,302.5 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,726,793.5 мянган төгрөг болж 38,820.9 мянган төгрөгөөр өссөн нь 103,395.2 мянган төгрөгийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөр худалдан авсан, НҮБ-аас хэрэгжиж буй “Орон нутгийн иргэдэд түшиглэсэн уур амьсгалын өөрчлөлт тэсвэртэй ус хангамж эрүүл ахуйн үйлчилгээ” төслөөс 163,882.1 мянган төгрөгийн гүний худаг, тохижилтын ажил, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2021.12.28-ны өдрийн 154 дүгээр тогтоолоор “Топ ган дриллинг” ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор гүйцэтгэсэн Гийх наран хорооллын инженерийн шугам сүлжээний 222,412.0 мянга, 2021.06.21-ний өдрийн 79 дүгээр тогтоолоор 766.0 мянган төгрөгийн дизель моторыг Баян-Өндөр сумын ЗДТГ-аас үнэ төлбөргүй шилжүүлэн авсантай холбоотой байна.

Мөн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2021.02.11-ний өдрийн 28 дугаар тогтоолоор 29,087.9 мянган төгрөгийн өртөгтэй автомашиныг аймгийн Цагдаагийн газар

руу балансаас баланст шилжүүлсэн, 2021.04.01-ний өдрийн 43 дугаар тогтоолоор 8,899.7 мянган төгрөгийн хөрөнгө акталж 1,111.9 мянган төгрөгийн хөрөнгийг буцаан орлого авсан байна.

Богино хугацаат өр төлбөрийн дансны үлдэгдэл 29,036.9 мянган төгрөг болж 154,227.5 мянган төгрөгөөр буурсан нь татварын өглөг 99,758.9 мянга, дансны өглөг 54,468.6 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 84,361.3 мянган төгрөг болж 51,315.3 мянган төгрөгөөр буурсан ба энэ нь төгрөг, Хас банкнаас авсан зээлийн үлдэгдэл 51,315.3 мянган төгрөгийг тайлант хугацаанд барагдуулсантай холбоотой байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 7,092,081.4 мянган төгрөг болж 400,913.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны хуримтлан үр дүн 45,171.8 мянга, эздийн өмчийн бусад хэсэг 355,742.1 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 595,487.1 мянган төгрөг байгаа ба тайлант онд өөрчлөлт гараагүй болно.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Чандмань Баянхонгор ХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2021 оны 02 дүгээр сарын 05-ны өдрийн анхдугаар хуралдаанаар эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 2,037,661.7 мянган төгрөгөөр, нийт зардлыг 2,136,540.5 сая төгрөгөөр, ашиг/алдагдлыг 98,878.8 мянган төгрөгөөр тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 264,850.0 төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 2,195,088.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,129,886.4 мянган төгрөгийн зардал гарган 65,202.2 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,107,322.9 мянга, үндсэн бус үйл ажиллагааны орлогоос 87,765.8 мянган төгрөгийн орлого бүрджээ.

Тайлант онд 2020 оны 211 дүгээр тогтоолоор “Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” тухай тогтоолоор айл өрх, Аж ахуй нэгжийн цэвэр бохир ус дулааны үнийг 2020.12.01-нээс 2021 оны 12 сарын 31 хүртэл хөнгөлсөнтэй холбоотой Засгийн газраас 1,318,238.4 мянган төгрөг санхүүжилт орж ирсэн байна. Сумдын зөөврийн усны хөнгөлөлтөөс 2021 оны 9 сараас 7,837.0 мянган төгрөгийг шилжүүлээгүй санхүүгийн тайланд өглөг үүсгэсэн байна.

д/д	үзүүлэлт	Бүгд дүн
1	Аж ахуй нэгж байгууллага	201,929.3
2	айл өрх	301,255.4
4	Сумын худаг	94,715.5
5	Баянхонгор сумын зөөврийн ус	242,900.0
6	Халаалт	477,438.1
	НИЙТ ДҮН	1,318,238.4

Эх сурвалж: үйл ажиллагааны тайлангаас

Нийт орлогын гүйцэтгэл 2,037,661.7 мянган төгрөг болж төлөвлөснөөс 157,426.9 мянган төгрөг буюу 107.7 хувиар нэмэгдсэн нь дулаан хангамжийн үнэ тариф өссөнөөс 67,729.6 мянга, гэр хорооллын өрхийн усны төлбөрийг төрөөс хөнгөлсөнтэй холбоотой 43,888.7 мянган төгрөгийг давуулан биелүүлсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2,129,886.4 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 6,654.1 мянган төгрөг буюу 99.7 хувиар гүйцэтгэлтэй байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 15 нэр төрлийн 264,850.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээ төлөвлөснөөс гүйцэтгэлээр 6 төсөл арга хэмжээний 26,595.0 мянган төгрөгийг өөрийн хөрөнгөөр, 2 төсөл арга хэмжээний 198,750.0 мянган төгрөгийг НҮБ болон аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөр гүйцэтгэсэн байна.

Тус байгууллагын орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Хүснэгт 2. 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/мянган төгрөг

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
				Төлөв-лөгөө	Гүйцэтгэл		
1	Цэвэр усан хангамж	мян.төг	595,073,500.0	657,484,400.00	658,805,100.00	- 1,320,700.0	100.2
	УТБ	мян.төг	101,133,500.0	196,099,200.0	239,987,900.0	- 43,888,700.0	122.4
	Ариутгах татуурга	мян.төг	361,854,600.0	412,902,600.00	410,974,170.00	1,928,430.0	99.5
	Суурь хураамж	мян.төг	102,125,400.0	112,045,600.0	110,467,160.0	1,578,440.0	98.6
	Дулаан хангамж	мян.төг	581,639,800.0	607,835,000.00	675,564,620.00	- 67,729,620.0	111.1
	Бусад орлого	мян.төг	106,507,600.0	51,294,900.0	99,289,700.0	- 47,994,800.0	193.6
2	Нийт орлого	мян.төг	1,848,334,400.0	2,037,661,700.0	2,195,088,650.0	- 157,426,950.0	107.7
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	1,741,826,800.0	1,986,366,800.0	2,095,798,950.0	- 109,432,150.0	
3	Нийт зардал	мян.төг	1,981,550,860.11	2,136,540,500.00	2,129,886,430.00	6,654,070.0	99.7
	Үүнээс:						
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	мян.төг	1,896,225,860.11	2,062,735,520.00	2,016,212,000.00	46,523,520.00	97.74
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	мян.төг	36,993,200.00	48,365,469.58	50,275,792.49	(1,910,322.91)	103.95
	в) Хөрөнгө оруулалт их засвар	мян.төг	48,331,800.00	48,290,500.00	40,992,400.00	7,298,100.00	84.89
4	Цэвэр ашиг, алдагдал	мян.төг	(133,216,460.11)	(98,878,820.00)	65,202,307.00	(164,081,127.00)	

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Чандмань-Баянхонгор ХК-ний 2021 оны орлого, зардлын төлөвлөгөө

Тайлант хугацаанд ажиллагсдын цалин, НДШ-ийн зардлаас 19,616.6 мянга, ТУЗ-ын цалин НДШ-аас 2,616.9 мянга, нийгмийн хамгаалал ажиллагсадтай холбоотой зардлаас 33,416.0 мянга, татвар төлбөр хураамжийн зардлаас 6,206.4 мянга, сэлбэг хэрэгслийн зардал 20644.4 мянга, засвар үйлчилгээний зардал 7,298.1 мянга төгрөгийг Засгийн газрын 43 дугаар тогтоолтой холбоотойгоор хэмнэсэн байна.

Мөн ашиглалтын зардлаас 12,328.4 мянга, үндсэн бус үйл ажиллагааны зардлаас 62,703.4 мянган төгрөгийг хэтрүүлсэн байна. Энэ нь аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021.02.01-ний өдрийн 23 дугаар тогтоолоор 33868.8 мянган төгрөгийн найдваргүй авлагыг данснаас хассан, 2021.02.11-ний өдрийн 28 дугаар тогтоолоор 29,087.9 мянган төгрөгийн өртөгтэй автомашиныг аймгийн Цагдаагийн газар руу балансаас баланст шилжүүлсэн, 2021.04.01-ний өдрийн 43 дугаар тогтоолоор 8,899.7 мянган төгрөгийн хөрөнгө акталсан, Төрөөс ундны усны үнийг тэглэсэнтэй холбоотой 15 зөөврийн ус түгээх байрны зөрүү үнэнд 40,778.5 мянган төгрөгийг олгосонтой холбоотой байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Чандмань-Баянхонгор ХК-ны 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг дарга М.Мөнхбат танд танилцуулж байна

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төрийн өмч, хөрөнгийн зарцуулалт, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Чандмань-Баянхонгор ХК-ны 2021 оны санхүүгийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 15-ны өдөр ирүүлсэн.

Тайлант жил хөрөнгө зарцуулахад нэгдүгээр гарын үсгийг Чандмань-Баянхонгор ХК-ны гүйцэтгэх захирал М.Мөнхбат, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Наранцэцэг нар зурсан байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгээгүй байна.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Чандмань-Баянхонгор ХК-ны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт орлого 1,848,334.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 18,483.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 12,938.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогоос гүйцэтгэлийн материаллаг байдлыг тооцоход 3,467.5 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 12 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	4	4	4	0	
2	Хагас жил	0	0	0	0	
3	Улирал бүр	0	0	0	0	
4	Сар бүр	2	24	21	3	
5	Тухай бүр	6	72	66	6	
	Нийт	12	100	91	9	0

Чандмань Баянхонгор ХК нь тайлант онд нийт 578,726.9 мянган төгрөгийн 100 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 41,285.5 мянган төгрөгийн 9 мэдээллийг хугацаа

хоцроож байршуулсан байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 190,286.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3,700.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 45,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 12,250.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 129,336.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн байна..

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	45,000.0	1	45,000.0			
Албан шаардлага	1	12,250.0	1	12,250.0	0	0	0
Зөвлөмж	4	129,336.2	4	129,336.2			
Нийт дүн	6	186,586.2	6	186,586.2	0	0	0

Эх сурвалж: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын статистик мэдээ

Зөвлөмжийн биелэлтийг Чандмань Баянхонгор ХК-ний гүйцэтгэх захирлын 2021.06.30-ны өдрийн 175 тоот албан бичиг ирүүлсэн байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 75,676.8 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 9,465.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт , 66,211.7 мянган төгрөгийн алдаа зөрчил давтан гаргахгүй гаргахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүлээ.

Аудитаар илэрсэн материаллаг алдаа нь гүйцэтгэлийн шатанд тооцсон материаллаг байдлын түвшнээс хэтрээгүй тул "Зөрчилгүй" санал дүгнэлт өгөв.

8.1 Төлбөрийн акт

1.Аймгийн Засаг даргын 2021.05.14 -ний өдрийн А/311 дугаар захирамжаар дулаан үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн уурын зууханд усны шүүлтүүрийг туршилтаар хийхээр ажлын хэсэг томилон аж ахуй нэгжүүдээс усны шүүлтүүрийн тэнцүү хуваан гаргаж суурилуулсны дараа аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс буцаан олгох шийдвэр гарсан байна. Үүний дагуу 2021.05.14-нд иргэн Д.Мөнхжаргал 7,000.0 мянган төгрөг шилжүүлсэн ба тухайн ажил хийгдээгүй санхүүгийн тайланд авлагаар тусгасан бөгөөд 2022.01.17 онд 1,609.7 мянган төгрөгийг буцааж тушаасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Усны шүүлтүүрийн үнэ 5,390.3 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант хугацааны худалдан авсан бараа ажил, үйлчилгээний баримтыг тулгахад 40,748.2 мянган төгрөгийн 36 гүйлгээний анхан шатны баримтад и-баримтыг хавсаргаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан

хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа, ажил үйлчилгээ нийлүүлэгч аж ахуй нэгж, хувь хүмүүсээс суутган тооцоо хийж 4074.8 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

8.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Чандмань Баянхонгор ХК нь тайлант онд нийт 578,726.9 мянган төгрөгийн 100 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 41,285.5 мянган төгрөгийн 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээг хугацаанд үнэн зөв байршуулж зөвлөмж хүргүүлээ.

2. Удирдлагын дээд болон дотоод хяналт

Илрүүлэлт: Тайлант хугацаанд үйл ажиллагааны зардлаас ажиллагсдын хоолны зардал 3,528.6 мянга, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар 623.0 мянга, байгалийн нөөц ашигласны төлбөр 2,532.7 мянга, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 7,358.3 мянга, аудитын төлбөр 2,500.0 мянга, төрөл бүрийн шимтгэл хураамж 433.9 мянга, түрээсийн зардал 1,743.0, харилцаа холбооны зардал 2,394.7 мянга, шатах тослох материал 7,316.1 мянга нийт 24,926.2 мянган төгрөгийг тус тус хэтрүүлэн зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ-ын тогтоолоор батлагдсан бизнес төлөвлөгөөний дагуу зарцуулалтыг гаргаж байх, зардал хэтрэхээр тохиолдолд төсөвт тодотгол хийж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Чандмань Баянхонгор ХК	БНА-2022/2/НА-СТА-ОНӨАН	Аймгийн Засаг даргын 2021.05.14-ний өдрийн А/311 дугаар захирамжаар дулаан үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн уурын зууханд усны шүүлтүүрийг туршилтаар хийхээр ажлын хэсэг томилон аж ахуй нэгжүүдээс усны шүүлтүүрийн тэнцүү хуваан гаргаж суурилуулсны дараа аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс буцаан олгох шийдвэр гарсан байна. Дээрх шийдвэрийн дагуу ажлын хэсгийн ахлагч Д.Мөнхжаргалд 7,000,000 төгрөгийг 2021.05.14-нд шилжүүлж тухайн ажил хийгдээгүй санхүүгийн тайланд авлагаар тусгасан бөгөөд 2022.01.17 онд 1,609,675 төгрөгийг буцааж тушаасан байна.	Усны шүүлтүүрийн үнэ 5096 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.	1	5,390.3					1	5,390.3				
2	Чандмань Баянхонгор ХК	БНА-2022/1/НА-СТА-ТӨҮГ	Тайлант хугацааны худалдан авсан бараа ажил, үйлчилгээний баримтыг тулгахад 40,748.2 мянган төгрөгийн 36 гүйлгээний анхан шатны баримтад и-баримтыг хавсаргаагүй байна.	Бараа, ажил үйлчилгээ нийлүүлэгч аж ахуй нэгж, хувь хүмүүсээс суутган тооцоо хийж 4074.8 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.	1	4,074.8					1	4,074.8				
3	Чандмань Баянхонгор ХК	БНА-2022/1/НА-СТА-ТӨҮГ	Тайлант хугацаанд ажиллагсдын хоолны зардал 3,528.6 мянга, байгалийн нөөц ашигласны төлбөр 2,532.7 мянга, түрээсийн зардал 1,743.0, харилцаа холбооны зардал 2,394.7 мянга, шатах тослох материал 7,316.1 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна.	ТУЗ-ын тогтоолоор батлагдсан бизнес төлөвлөгөөний дагуу зарцуулалтыг гаргаж байх, зардал хэтрэхээр тохиолдолд төсөвт тодотгол хийж байх.	1	24,926.2									1	24,926.2
ДҮН					3	34,391.2					2	9,465.1			1	24,926.2

“Чандмань-Баянхонгор” ХК-ны 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал

Чандмань Баянхонгор ХК	БНА- 2022/1/НА- СТА-ТӨҮГ	Чандмань Баянхонгор ХК нь тайлант онд нийт 578,726.9 мянган төгрөгийн 100 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст илтөд байршуулахаас 266,085.5 мянган төгрөгийн 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээг хугацаанд үнэн зөв байршуулж зөвлөмж хүргүүлээ.	1	41,285.5										1	41,285.5
ДҮН				1	41,285.5										1	41,285.5
НИЙТ ДҮН				4	75,676.7				2	9,465.1					2	66,211.7